



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 06 сарын 08 өдөр

Дугаар А/ЗМ

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ын "б", 29.1.3-ын "л" заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ховд хотын нийтийн эзэмшлийн гудамж талбай, зам дагуу зүлэг, цэцэг тарих, услалтын систем суурьлуулах ажлыг хүлээн авах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Баярсүх – Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга

Гишүүд: Д.Бөхболд – Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтэн

Х.Баярлах - Жаргалант сумын Захирагчийн ажлын албаны мэргэжилтэн

Л.Дорждэрэм – Хот тохижуулах газрын дарга

Нарийн бичгийн дарга: Х.Баасанхүү - Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

2. Ховд хотын нийтийн эзэмшлийн гудамж талбай, зам дагуу зүлэг, цэцэг тарих, услалтын систем суурьлуулах ажлыг захиалагчаас баталсан техникийн тодорхойлолт, ажлын даалгаврын дагуу шалгаж хянан баталгаажуулж, шийдвэр гаргахыг ажлын хэсгийн ахлагч /Б.Баярсүх/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ  Т.ЖАРГАЛСАЙХАН



D/Zax-A/311-Da 02 01061